

БАТЛАВ
 ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН
 ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
 С.ЭНХБАЯР
 2024 оны 7 дугаар сарын 16 өдөр

ХАН-УУЛ ДҮҮРГИЙН 15 ДУГААР ХОРОО, 130 ДУГААР СУРГУУЛЬ БОЛОН 218 ДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН УРД ТАЛД ТОХИЖИЛТ ХИЙХ АЖЛЫН ЗУРГИЙН ДААЛГАВАР

2024 оны 7 дугаар сарын 16-ны өдөр

Улаанбаатар хот


1.	Төсөл боловсруулах үндэслэл	<ul style="list-style-type: none"> - Хан-Уул дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 16 дугаар тогтоол. - МЗХ2018/03-30 дугаартай тохижилтын архитектур төлөвлөлтийн даалгавар.
2.	Байршил, эдэлбэр газрын хэмжээ	<ul style="list-style-type: none"> - Хан-Уул дүүргийн 15 дугаар хороо, 130 дугаар сургууль болон 218 дугаар цэцэрлэгийн урд тал.
3.	Одоогийн байдал	<ul style="list-style-type: none"> - Одооо байгаа зам талбай эвдэрч муудсан. - Сул шороон хөрстэй.
4.	Төсөл боловсруулах үе шат	<ul style="list-style-type: none"> - Талбайн судалгаа, хэмжилт хийх. (Ажлын тоо хэмжээг захиалагч байгууллагатай зөвшилцөн батлуулах) - Загвар зураг боловсруулж батлуулах. - Ажлын зураг боловсруулах, ажлын технологи хийх аргачлалыг тодорхой харуулсан байх. (магадлал хийгдсэн байх). - Төсөвт өртөг (магадлал хийгдсэн байх). - Батлагдсан зураг төслийн дагуу ажил гүйцэтгэх.
5.	Төслийн захиалагч	<ul style="list-style-type: none"> - Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газар.
6.	Орон зайн төлөвлөлтөд тавигдах шаардлага	<ul style="list-style-type: none"> - Архитектур орон зай төлөвлөлтийг тус байршлын онцлог, шаардлага, орц гарц, орчны ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулж тохижилтын шийдэл гаргаж төлөвлөх. <u>Ногоон байгууламж:</u> <ul style="list-style-type: none"> - Одоо байгаа мод, бут, сөөгийг гэмтээхгүй шинээр Монгол орны уур амьсгалд тохирсон шилмүүст болон навчит мод, бут, сөөг, зүлэг тарьж ногоон байгууламжийг нэмэгдүүлэх. - Цэцэгт байгууламжийн хийцлэл төлөвлөж санал танилцуулах. - Ногоон байгууламжийг хамгаалсан хайс төлөвлөх. (модон шонтой) - Хот суурин газрын цэцэрлэгжүүлэлт, ногоон байгууламжийн төлөвлөлт UCS0801A мөрдөх. <u>Явган болон унадаг дугуйн зам талбай:</u> <ul style="list-style-type: none"> - Зорчигчдын амрах талбай болон хүний хөдөлгөөнийг салгаж зорчигчдын хөдөлгөөнийг сайжруулах орц гарцыг нэмэгдүүлж төлөвлөх. - Явган хүн хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар MNS 6056:2009 стандартыг мөрдөх. - Явган замыг өвлийн улиралд халтирдаггүй гадаргуутай хавтангаар төлөвлөж, тайлбарт тусгах. - Явган хүний зам, талбайн төлөвлөлт, хучилт, угсралтад тавигдах ерөнхий шаардлага UCS0901B стандартыг мөрдөх. - Унадаг дугуйн зам төлөвлөх. - Унадаг дугуйн замын төлөвлөлт, хучилтад тавих ерөнхий шаардлага UCS0903B стандартыг мөрдөх. <u>Бусад:</u> <ul style="list-style-type: none"> - Гэрлтүүлэг, сандал, сүүдрэвч, хогийн сав гэх мэт тохижилтын бусад элементийг төлөвлөх.

7.	Инженерийн дэд бүтцэд тавигдах шаардлага	<ul style="list-style-type: none"> - Гэрэлтүүлгийн тоног төхөөрөмжид тавих ерөнхий шаардлага UCS1901B стандартыг мөрдөх. Одоо ашиглагдаж байгаа нийтийн эзэмшлийн гудамж зам гэрэлтүүлгээс тэжээл авах. - Гадаргуугийн ус зайлуулах шийдлийг орчны байгууламжуудтай уялдуулан нэгдсэн байдлаар иж бүрэн шийдвэрлэх.
8.	Төсөл боловсруулахад ашиглах материал	<p><u>Хууль тогтоомжууд:</u></p> <ul style="list-style-type: none"> - Газрын тухай хууль - Барилгын тухай хууль - Усны тухай хууль - Хот байгуулалтын тухай хууль - Эрчим хүчний тухай хууль - Хог хаягдлын тухай хууль - Бусад хуулиуд <p><u>Норм, нормативууд:</u></p> <ul style="list-style-type: none"> - Барилгын инженер геологийн ажил /БНБД 11-03-01/ - Барилгын геодезийн ажил /БНБД 11-08-06/ - Барилга захиалагчийн дүрэм - Барилгын бүтээц ба суурийн найдваршил. Ерөнхий шаардлага /БНБД 20-01-11/ - Газар хөдлөлийн бүс нутагт барилга төлөвлөх барилгын норм ба дүрэм /БНБД 22-01-01*/ - Барилгад хэрэглэх уур амьсгал ба геофизикийн үзүүлэлт /БНБД 23-01-09/ - Барилгын төсөв зохион дүрэм /БНБД 81-95-12/ - Цахилгаан техникийн ажил /БНБД 3.05.06-90/; - Бусад холбогдох норм, дүрэм <p><u>Стандартууд:</u></p> <ul style="list-style-type: none"> - "Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Эрүүл ахуй. Ажлын байрны орчин, эрүүл ахуйн шаардлага" MNS 4990:2000 - "Ажлын байрны бичиг цаг уурын эрүүл ахуйн хэмжээ" MNS 12.013-91 - "Ажлын байрны хүчдэлийн түвшин" MNS 12.097-91, MNS 12.098-91, MNS 12.101-091 - Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөтөч зам, налуу шатыг шийдэх /MNS 6056:2003, 6055:2009/; - Иж бүрэн гудамж: Хашаа, хайс, хашлагад тавигдах ерөнхий шаардлага, хэрэглээ /UCS0001-02:2019/ - Бусад холбогдох стандартууд
9.	Эдийн засгийн тооцоо, төсөв	<ul style="list-style-type: none"> - Эдийн засгийн тооцоо болон төсвийг БНБД 81-95-12 болон эрх бүхий байгууллагаас зөвшөөрсөн программаар тооцох.
10.	Онцгой нөхцөл	<ul style="list-style-type: none"> - Тохижилтын стандарт мөрдөн төлөвлөх. - Хотын стандартын удирдамж, арга зүйн баримт бичиг мөрдөх.

ХЯНАСАН:

ТОХИЖИЛТ, НИЙТИЙН АЖ АХУЙН ХЭЛТСИЙН
ДАРГА  Г.ТУЯАЦЭЦЭГ

БОЛОВСРУУЛСАН:

ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛИЙН УДИРЛАГЫН ХЭЛТСИЙН
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН  О.МӨНГӨНШАГАЙ

Хан-Уул дүүргийн 15 дугаар хороо, 130 дугаар сургууль болон
218 дугаар цэцэрлэгийн урд тал.

